



ИТГЭЛ БА ГЭР БҮЛҮҮД

Ахлагч Рассел М.Нелсон

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Залуу Насанд Хүрэгчдэд Зориулсан СБС Галын Дэргэдэх Ярилцлага
2005 оны Хоёрдугаар сарын 6 • Бригам Янгийн Их Сургууль

Энэ онцгой үйл явдлын үеэр та нартай хамт байгаадаа би сэтгэл хангалуун байна. Нелсон эгч ханиад хүрч мөн ханиалгаад байгаа учир гэртээ үлдсэнд уучлаарай. Залуу насанд хүрэгчдийн энэ их цугларалтыг хараад би үнэхээр гайхан биширч байна. Үүнээс ч олон нь Хойд Америк, Төв Америк, Өмнөд Америк, Европ, Ази, Африк болон арлын орнуудад цугласан байгаа. Их Эзэний Сүнс бидэнтэй хамт байгаасай хэмээн би залбирч байна. Мөн энэ үйл явдал нь 28 хэл дээр орчуулагдаж байгаа болохоор бид орчуулагч нарынхаа төлөө залбиръя.

Залуу насанд хүрэгч бүрт би Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли, Ерөнхийлөгч Томас С.Монсон, Ерөнхийлөгч Жеймс И.Фауст болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ах нарын мэндчилгээ хийгээд хайрыг авчирлаа. Итгэлийн тань төлөө, сүсэг бишрэлийн тань төлөө, Их Эзэнд үйлчлэх хүслийн тань төлөө бид та бүхэнд талархаж байна.

Би та нарыг түр зуур, ердөө ганц хором тэмдэглэл хөтлөхөө зогсоод өөрийн зан чанар, сүнсээ анхааралтай шинжихийг хүсч байна. Энэ орой та нар эрч хүчтэй мөн залуу байна. Та нарын ихэнх нь ирээдүйдээ агуу хүсэл эрмэлзлэлээр дүүрэн оюутнууд байгаа. Одоо бодохыг би та нараас хүсч байна. Би та нарыг өөрсдийгөө, одоо хэн байгааг биш харин одоогоос 50 жилийн дараа хэн болсон байгаа бодохыг хүсч байна. Төсөөллийнхөө нүдээр тэр үед байгаа өөрийгөө хар даа. Та нарын уужим ухаан, нарийн бэлхүүс байраа солисон байна уу. Та нар ажил мэргэжлээ дуусгажээ. Цагны хонх цохих, эсвэл төлбөрийн хуудас цуглуулдаг ажлын өдрүүд тань байхгүй болжээ. Та нар ч мөн ингэж төсөөлж байна уу?

Надад дараах асуултууд байна: Та нар одоогоос 50 жилийн дараа өөртөө юу *харж* байна? Та нар одоогоос 50 жилийн дараа *хэн* байхыг хүсч байна? Та нар одоогоос 50 жилийн дараа бүхнээс илүү юуг *үнэхээр хүсч* байна вэ?

Би та нарын оюун ухаан ажиллаж байгааг сонсож чадна гэж бодож байна. Та нарын зарим нь “Би одоогоос 50 жилийн дараа амьд байхыг л хүсч байна” гэж

хэлж болох юм. Энэ бол тийм ч муу санаа биш юм. Аваар болон өвчин зовлон нь одоогоос 50 жилийн дараа та нарын заримыг энд байлгахгүй тэрхүү мөнх бус байдлын нэг хэсэг юм. Гэвч ихэнх нь байх болно. Тиймээс тайлбарыг бус тогтсон дэг журмыг төлөвлө. Та нарын зарим нь ирээдүйдээ нэр алдар, эсвэл амжилтыг харж байгаа. Мөн та нарын ихэнх нь гэр бүлийг хүсч байгаа.

Хэрэв Нелсон эгч энд байсан бол, Нелсон эгчийг миний дэргэд зогсоосой гэж би хүсэх байлаа. Их Эзэн дотор эмэгтэй хүнгүйгээр эр хүн гэж үгүй.¹ Бид хамтдаа байсан бол юу болохыг хүсч байгаагаа төлөвлөж, мөн тэмүүлэхэд та нарт тусалж чадах байсан юм. Миний өнөөдрийн ярих сэдэв маань “Итгэл ба Гэр Бүлүүд”. Би итгэлийг зорилготойгоор эхэнд нь тавьсан юм. Энэ нь бидний гэрлэсэн амьдралд: *эхлээд* Бурханы хаант улсыг эрэлхийлэх гэсэн алтан гадас од маань болдог. Бид Их Эзэнд гуйвшгүйгээр итгэх нь гэрлэгсдийн амьдрал хийгээд хайрыг баяжуулдаг гэдгийг сурсан. Түүнд итгэх итгэл нь хайрлах чадвар болон чанар хоёуланг нь өсгөдөг.



50 гаруй жилийн өмнө бид та нартай адил залуу насанд хүрэгчид байсан билээ. Энэ зургийг тэр үед авсан юм. Бид хоёулаа их сургуулийн оюутан байв. Би анагаа-

хын хоёрдугаар курсын оюутан, энэ маань нэгдүгээр курсын оюутан байлаа. Бид бие биедээ маш их хайртай байсан юм. Үүнийг та нар энэ зурган дээрээс харж байгаа гэж би бодож байна. Ах нар аа, та нар миний түүнд хайртай байсныг минь буруутгахгүй биз дээ.

Гэрэл зургийг үзүүлсэнд баярлалаа. Бид дахин ийм байгаа больсон. Гэвч, миний хувьд, Нелсон эгч өмнөхөөсөө илүү үзэсгэлэнтэй болсон!

Миний анагаахын докторын мэргэжил дууссан. Миний тэр олон мэс заслууд бүгд хийгдэж дууссан. Үүнтэй адил, Нелсон эгч арван хүүхдийн эхийн хувьд агуу үүрэг хариуцлагыг үүрсэн. Хүүхдүүдийн маань эхний ес нь бүгд жижиг охид байсан гэдгийг би хэлэхээ мартчихаж. Ганц хүүг минь иртэл манай гэр яг охидын дотуур байр шиг байв. Хөөрхий хүү минь! Эхний хоёр жилийн турш жинхэнэ ээж нь хэн болохыг мэддэггүй байлаа.

Одоо Нелсон эгчийн амьдрал сайжирсан. Тэр одоо энэ үдэш олон нь энд байгаа ач хүүхдүүдийн маань эмээгийн тийм ч хатуу чанд бус үүргийг авсан. Гэр бүлийн маань бүх гишүүд түр босно уу? Би камерийн операторыг бусад бүх хүмүүс эднийг харж болохоор гэр бүл рүү маань чиглүүлэхийг хүсье. Бид 56 ач болоод 14 гучаар адислагдсан юм. Зөвхөн хоёр долоо хоног болж байгаа манай хамгийн бага ач энд байна. Энэ тоо өссөөр л байна.

Би гэр бүлийнхээ 106 гишүүний хүн тус бүрийн зургийг үзүүлье гэж бодсон. Тэгснээ онгоцонд харийн хүний дэргэд суугаад явж байгаа эмээг бодсон юм. Гэр бүлийн тухай яриа нь түүнийг дэргэдээ суугаа хүнээс “Би танд ач хүүхдүүдийнхээ зургийг үзүүлсэн билүү?” гэж асуухад тэр “Үгүй ээ! Баярлалаа” гэж хариулав.

Тиймээс би өөр зураг үзүүлэхгүй. Энэ нь ямар ч тус болохгүй. Гэр бүлийн маань сайн сайхан бие махбодийнхоос хавьгүй илүү. Энэ нь сүнслэг. Аль ч хоёр гишүүн нь адилхан биш. Бүгд өвөрмөц шинжтэй хийгээд онцгой.

Нелсон эгч бид хоёрт одоо хамгийн чухал нь юу вэ? Энэ бол бид хоёр эхнэр нөхөр бөгөөд цаг зуур хийгээд үүрд мөнх холбогдсон явдал юм. Хүүхдүүд маань гэрээнд төрж, бидэнтэй мөнхөд холбогдсон. Ямар агуу баяр баясгалан, мэдлэг авчирна вэ!

Бид ариун сүмд гэрлэж байхдаа тийм ч их судар мэддэг байгаагүй. Гэхдээ бид Матай 6:33-ыг мэдэж байсан: “Харин эхлээд түүний хаанчлал болон Түүний зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно.” Нилээн өмнө дурдсанчлан энэ нь бидний хамтдаа хийсэн шийдвэр бүрийн маань алтан гадас од болсон юм. Бүр хэдэн жилийн дараа бид “Энэ дэлхийн зүйлсийг бүү эрэлхийл, харин эхлээд Бурханы хаант улсыг байгуулж, түүний зөв шударгыг бий болго, тэгвэл эдгээр бүх зүйлс та нарт нэмэгдэх болно” (ИСО, Матай 6:33) хэмээсэн Иосеф Смитийн Орчуулгаас энэ шүлэг илүү тодорхой бөгөөд ойлгомжтой болохыг бид сурч авсан юм.

Бид энэ судраар маш сайн удирдуулсан! Миний дэргэд энэ олон жилийн турш зогсож буй энэ итгэлтэй эмэгтэй надад маш их бурханлигаар нөлөөлсөн юм. Миний хувьд маш учир утгатай адислалууд түүний улмаас ирсэн юм.

Цаг хугацаа хагас зуунаар өөрчлөгджээ. Дэлхий сүнслэг байдлаараа өвчинд баригдан доройтжээ. Тэр өвчин маш хурднаар ихэд газар авчээ. Нүгэл үйлдүүлэх уруу таталт өнөөдөр бидний үеийнхээс илүү хурц болсон байна. Та нар материаллаг зорилттой нягт холбогдсон хэрэглэгчийн соёл иргэншил рүү орж байна. Олон түмэн аминч үзлийн бунханд мөргөдөг. Чанга дуу хоолойнууд амьдралын бүх хэв маяг адил тэнцүүгээр үнэлэгдэнэ гэсэн хуурамч сургаалыг хамгаалж байна. Хүмүүс үүрэг хариуцлагаасаа илүүтэйгээр эрх мэдлийг хүсч байна. Гэд гэгээрэхээсээ илүү эрх олж авахад санаа зовж байх шиг санагддаг. Эцгүүдийн үүрэг долоо хоног тутам эргэж, санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр тодорхойлогдож байна. Товчхондоо бид ёс суртахууны үнэ цэнийг урвуу нь харуулсан байдалтай тулжээ.

Сүмийн залуу насанд хүрэгчид та нар энэхүү сүнслэг байдлаар доройтсон орчинд дэлхийд ирж байна. Та нарт итгэлийн бат бөх суурь байдаг билээ. Та нар болзоо болон гэрлэлтийн аль алинд нь үлгэр дууриал болдог билээ. Та нар юу буруу, юу зөвийг мэддэг. Та нар үнэнд баттай хэвээр байдаг. Та нар Их Эзэний заасан зүйлүүдийг мэддэг билээ. Тэгээд та нар тэдгээрийг өөрсдийнхөө хүүхдүүд болон ач, зээ нартаа заах болно. Та нар бол “Израилын Найдвар, Сионы арми бөгөөд Амлагдсан өдрийн хүүхдүүд”² юм. Та нарт биднийг та нарын насан дээр байх үед бидэнд байснаас хавьгүй илүү их сүнслэг хүч байдаг. Та нар амьдралын тулааны талбарт явж байхдаа “ялгуусан их алдар суунд зөв шударга байдал болон Бурханы хүчээр зэвсэглэсэн . . . газрын . . . гадаргуугаар нэг тархсан . . . Их Эзэний гэрээ байгуулсан хүмүүстэй” хамт тоологддог (1 Нифай 14:14). Бид та нараар маш их, бүр ихээр бахархдаг!

Нелсон эгч бид хоёр амьдралаа эргэн харахдаа гэр бүл болон Сүм дэх гишүүнчлэл маань бидэнд хамгийн чухал гэж бид үнэнчээр хэлж чадна. Ариун сүмд гэрлэж, хүүхдүүдийг гэр бүлдээ урин, Их Эзэнд үйлчил гэсэн Сүмийн удирдагчдийн зөвлөгөөг сонссондоо бид хичнээн их талархаж байдаг гээч. Хэрэв бид өөрсдийнхөө боловсролыг гэр бүлээсээ *түүрүүнд* тавьсан бол одоо ингэж ихээр адислагдсан байхгүй л байх сан. Боловсрол бол бидний хувьд хэтэрхий урт

үйл явц байсан юм. Би докторын хоёр зэрэг хамгаалахад маш удаан хугацааг зарцуулсан. Дараа нь бид мэс заслаар мэргэших гэж илүү олон жил тэмцсэн юм. Би 12 жил гаран сурсан анагаах ухааны сургуулиа дүүргэх хүртлээ мэс заслын үйлчилгээнд зориулан ямар ч тооцооны хуудас илгээгүй юм. Тэгэхэд бид таван хүүхэдтэй болсон байлаа. Гэсэн хэдий ч, бид үүнийг зохицуулж чадсан юм.

Би Нелсон эгчийг хамгийн жижиг зүйлийг ч гэсэн хийх хэрэгтэй болсондоо хэзээ ч үглэж байгаагүйд нь хүндэтгэдэг. Би Бостон хотын төвд нэг орой болсон явдлыг эргэн дурсмаар байна. Бид Бойлстон Гудамжаар алхаж байлаа. Тэнд бид тавилгын дэлгүүрийн хажуугаар өнгөрөв. Нелсон эгч хамраа цонхны шилэнд наагаад “Бид хэзээ нэгэн цагт ширээний чийдэн авч дийлнэ гэж чи бодож байна уу?” гэж асуусан юм.

Ах нар аа, Би та нарыг хамтрагчаа сонгохдоо Нелсон эгч шиг алсын хараатай хүнийг эрж хайхыг санал болгож байна. Эгч бүрийн хувьд та нөхрөө хичнээн удаан цаг хугацаа шаардагдсан ч гэсэн өөрийнх нь хийж чадах бүхнийг нь хийхэд урамшуулан дэмжихийг санал болгож байна.

Бид амьдралын амжилт болон гэмшлээс аль алианаас нь амссан. Бид харуусал, өвчин, мөн хүүхдүүдийнхээ дундах үхлийг зохицуулж байсан юм. Гэвч үхэл нь ариун сүмд лашдан холбогдсон гэр бүлийг салгаж чадахгүй. Тэрхүү хэсэг хугацааны салангид байдал нь цаг зуурынх юм. Их Эзэний аз жаргалын агуу төлөвлөгөөнд талархан, агуу итгэл мөн өөдрөг үзэлтэйгээр бид ирээдүй дэх бүхэнтэй нүүр тулж чадна.

Нелсон эгч бид хоёр амьдрал бол нэг дүрт тоглолт биш гэдгийг сурсан юм. Тэнд үнэхээр мөнх бус байдлын өмнөх оршихуй гэж буй. Мөн үнэхээр үхлийн дараах амьдрал гэж буй билээ. Мөнх бус байдлын өмнөх мөнх бус байдлын хэсгүүд бол бидний мөнх бус байдлын дараах амьдралын маань зөвхөн оршил нь юм. Бошиглогчдод илчлэгдсэн алдар суугийн гурван хаант улсын тухай мэдлэг нь бидэнд мөнх бус байдлын дараах хэсгийг зэрвэс өгдөг.³ Мөнх амьдрал нь гайхамшигтай мөн олж авах нь үнэ цэнэтэй юм.

Мөнх бус байдлын өмнөх оршихуй нь бидний итгэлийг бэхжүүлэх чухал сургаалийн суурь болно. Мөнх бус байдлын өмнөх үед үүрдийн сайн мэдээ боловсруулагдсан байсан билээ. Ертөнцийн суурийг тавихаас өмнө авралын төлөвлөгөөг бэлтгэсэн билээ.⁴ Энэ нь Бурханы хаант улсыг өвлөх тэнгэрлэг гайхамшигтай боломжийг хамруулж буй билээ.⁵

Авралын төлөвлөгөөний гол цөм нь бол Есүс Христийн Цагаатгал юм. Мөнх бус байдлын өмнөх зөвлөлд Тэрээр өөрийнхөө Эцэгээр бидний нүглийг цагаатгахаар мөн сүнслэг болон бие махбодийн үхлийн гинжийг таслахаар урьдчилан томилогдсон юм.⁶ “Өөрийн хүмүүсийг гэтэлгэхээр, дэлхийн үүслээс бэлтгэгдсэн нь би болой. Надаар бүх хүмүүн төрөлхтөн амьдралыг хүртэх болно, бүр миний нэрэнд итгэх тэд мөнхийн түүнийг буюу” (Ифер 3:14) хэмээн Есүс тунхаглажээ. Дараа нь Паул Сүм бол “төлөөлөгч болон бошиглогчдийн суурин дээр босгогдож байгаа бөгөөд Есүс Христ өөрөө Булангийн чулуу нь юм” (Ефес 2:20) хэмээн нэмжээ.

Мөн түүнчлэн Бурханы төлөвлөгөөний нэг чухал хэсэг нь гэр бүл юм. Тэгэхээр, төлөвлөгөөний зорилго нь гэр бүлүүдийг аврах явдал юм. Дэлхий бүтээгдсэн нь мөнх бус байдлын өмнөх Тэнгэрлэг Эцгийн маань сүнсэн хүүхдүүд болох бид дэлхий дээр ирж бие махбодийг олж авах боломжтой болгосон. Бид энд хичээж мөн шалгагдах болно.⁷ Бид энд “эрх чөлөө болон мөнхийн амьдрал, . . . эсвэл боолчлол болон үхлийн сонгох эрхтэй байдаг” (2 Нифай 2:27). Тэгэхээр бүх сайн нь, бид хэн нэгэнд хайртай болж, гэрлэн, мөн гэр бүлдээ хүүхдүүдийг урих хэрэгтэй юм.

Тодорхой адислалууд хожмын өдрүүдэд өгөгдөхөөр хадгалагдсан билээ. Их Эзэн “дэлхийн сууриас эхлэн нууцлагдсан зүйлсийг” (Матай 13:35) илчлэхээр төлөвлөсөн. Тэдгээр зүйлүүдэд Мормоны Номонд тэмдэглэсэн илчлэлтүүд хамаарна.⁸ Мөн түүнчлэн ариун сүмийн ёслолууд мөн гэрээнүүд хамаарна.⁹ Их Эзэн “дэлхийн сууринаас өмнө нуугдмал байсан зүйлүүдийг, цаг хугацааны бүрэн байдлын эрин үед хамаарах зүйлүүдийг өөрийн хүүмүүст илчлэхийн тулд би зохих ёсоор авч үзнэ” (С ба Г 124:41) хэмээн Иосеф Смитэд тунхаглажээ.

“Нас барагсдын өмнөөс хийх баптисмын ёслол нь . . . дэлхийн сууринаас өмнө үндэслэгдсэн.” (С ба Г 124:33) “Сайн мэдээний тухай мэдэлгүйгээр нас барсан тэдний” (С ба Г 128:5) төлөө авралыг боломжтой болгохын тулд хийгдсэн юм. Эрин үеүдийг хооронд нь гагнах холбоосыг бий болгож, эрин үеүд, түлхүүрүүд, хүчүүд мөн алдарууд нь бүрэн, гүйцэт, төгс төгөлдөр байрандаа орно.¹⁰ Энэхүү эрин үеүдийн хамтын гагналт нь дэлхийн зорилгууд мөн Сүмийн зорилгуудад чухал бөгөөд хэрэв гэр бүлүүд ариун сүмд лашдагдгүй аваас аль алинд ялагдах болох болно.¹¹

Бидний мөнх бус амьдрал дахь бэлтгэл нь мөнх бус байдлын өмнөх оршихуйд эхэлсэн юм. Дэлхийн сууриас өмнө, бид бүхэн өөрсдийн тэнгэрлэг эцэг эхийн хамтаар сүнсэн хүүхдүүд болон амьдарч байсан юм. Бидний дунд агуу бөгөөд шударга нэгэн байсан билээ.¹² Абрахам,¹³ Иеремиа,¹⁴ Иосеф Смит,¹⁵ мөн бусад¹⁶ нь Бурханы бошиглогчид болон илгээгдэж, зарим нэг нь Түүний ариун нөлөөллийн дагуу алагдсан билээ.¹⁷ Санваарыг хүртээх жаяг нь “эцгүүдээс, цаг хугацааны эхлэлээс . . . бүр дэлхийн сууринаас өмнө ирсэн юм (Абрахам 1:3).

Их Эзэн бидэнд хамгийн дээдэх [селестиел алдарыг хүртэхийг заахдаа] “хүн санваарын энэхүү ариун жаягт [гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээг хэлж буй] орох ёстой;

Мөн хэрэв тэрээр үгүй аваас, тэрээр үүнийг олж авч чадах нь үгүй.” (С ба Г 131:2–3.)

Эгч нарт маш онцгой бэлэг өгөгдсөн. Их Эзэний дагуу “өсөн үржиж, мөн дэлхийг дүүргэхийг тулд, . . . дэлхийн сууринаас өмнө миний Эцэгээр өгөгдсөн амлалтыг хэрэгжүүлэх тулд, . . . мөнхийн дэлхийнүүд дэх тэдний өргөмжлөлийн тулд, тэд хүмүүний бодгалыг авчирч болохын тулд, . . . түүнд өгөгдсөн бөлгөө, учир нь тэрээр алдаршиж болохын тулд миний Эцэгийн ажил энд үргэлжилж буй” (С ба Г 132:63). Энэхүү зарлигийн гайхамшигийг бодоцгоо. Эх хүн хүүхдээ зохистойгоор төрүүлэн мөн асрах аваас, тэрээр зөвхөн дэлхийн бүтээлтэнд хариулж буй бус,¹⁸ тэрээр Бурханыг алдаршуулж буй!

Гэрээний хүүхдүүд бид Аврагчид үйлчлэхээр сонгогдсон юм. Төлөөлөгч Паул заахдаа: “Их Эзэн биднийг өөртөө дэлхийн үүслээс өмнө сонгосон” (Ефес 1:4).¹⁹ Тэрхүү урьдчилсан томилолтын нэг хэсэг нь, Түүний адислалуудыг хүлээн авахыг зөвшөөрсөн болзлыг Бурхан бий болгосон юм. Тэдгээр адислалууд нь Түүний адислалууд урьдчилан хэлэгдсэн хуулинд дуулгавартай байсан хүмүүс дээр өгөгдөх болно.²⁰

Тэдгээр болзлуудын нэг нь дэлхийн уруу таталтуудыг даван гарах бидний хэрэгцээнээс хамаардаг.²¹

Дэлхий бий болохоос өмнө Сатанаас эсрэг зүйл ирэх нь зөвшөөрөгдсөн байв.²² Тэрээр Аврагчийн ариун ажлын эсрэг байнга тэмцээр ирсэн бөгөөд цаашид ч тэмцэх болно. Тэрээр бошиглогчид мөн Сэргээлтийн судруудыг эсэргүүцсэн. Өнөө үед, Бурханы төлөвлөгөөний голт зүрх болсон гэр бүл рүү шууд дайныг хэрэгжүүлэхийг Сатан сонгосон билээ. Түүний довтолгооны тэмдгүүд бидний эргэн тойронд байна.

Нилээд тооны гэрлэсэн насанд хүрэгчдийн²³ төрөлтийн тоо багасч байна.²⁴ Хосуудын гэрлэлтийн нас²⁵ гэрлээгүй хамтран амьдрагчдын тоотой адил өссөөр байна.²⁶ Ёс суртахуунгүй явдал болон порнографи хурдацтай өсөн нэмэгдэж байна.²⁷

Энэхүү сүнслэг өвчлөлт бидний эргэн тойронд байгаа нь дайснаас ирэх довтолгоонуудын эсрэг зогсох Их Эзэн болон Түүний сайн мэдээнд итгэх жинхэнэ итгэлийг шаардаж байна. Биеийн болон сүнслэг, бүх бурханлиг бус зүйлсээс өөрсдийгөө холдуулахыг би та нараас шаардаж байна.²⁸ Сайн мэдээний төмөр бариулаас баттай зуур!

Ах эгч нар минь, дэлхий бүтээгдэхээс өмнө сайн мэдээ нь Бурханы мөнхийн төлөвлөгөөний гол цөм байсан билээ. Энэ бол эдүгээ сэргээгдсэн үүрдийн сайн мэдээ юм.²⁹ Ийм суурьтайгаар энэ Сүм, бүр Мянган жилийн турш ч,³⁰ байрнаасаа хөдлөх нь үгүй.³¹ Есүс Христийн сайн мэдээ бол бид өөрсдийнхөө итгэлийг дээр нь барьж болох бат суурь юм. Бидний зарим нь сул дорой; зарим маань хүчтэй. Бид салхиар туугдан давалгаалах тэнгисийн долгио мэт байж болно, (Жеймс 1:6), эсвэл сайн мэдээний мөнхийн үнэнүүдэд үндэслэгдэж мөн суурилсан сүнслэг төмөр бариулаас баттай зуурч чадна.³²

Тийм итгэл нь амьдралын асуудлуудаас хамгаалдаггүй боловч буруу явагдах үед тусалж чадна. Сайн хүмүүст муу зүйл тохиолдож болно. Осол гардаг. Гэр бүл болсон зарим хүмүүс хүүхдүүдээр адислагдахгүй байж болно. Зарим нь энэ амьдралд гэрлэж чаддаггүй, эсвэл тэд Бурханы зарлигуудыг дагахдаа алдаж буй хэн нэгэнтэй гэрлэдэг. Эдгээр нөхцөл байдлуудыг Их Эзэн анхааруулсан. Тэрээр итгэлтэй хүүхдүүдээ хадгалсан бүх адислалуудаа Өөрийнхөө замаар, мөн Өөрийн тогтоосон цагт түгээх болно.³³ Зөв шударга бай, гэвчээртэй бай, мөнхийн зорилготой бай, тэгснээр та хамгаалагдах болно.³⁴

Төлөөлөгчид мөн бошиглогчид нь олон жилийн турш дүрмийг заасаар ирсэн гэдгийг та анзаарах болно. Бид дүрмээс гажууд зүйл заадаггүй. Гажууд зүйл нь хувь хүний сонгох эрх ба хариуцлагаас хамаардаг. Их Эзэн биднийг төгс төгөлдөр бус дэлхийд амьдардгийг мэддэг. Тэрээр энэ нь “алдаст боловсорч гүйцээд байна” (С ба Г 18:6) гэдгийг мэднэ. Түүний шүүлт үнэнч, шударга мөн энэрэнгүй байх болно.

Арваад жилийн өмнө, Тэргүүн Зөвлөл мөн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга нь сүнслэг доройтлыг харан, дэлхий дахинаа өргөх гэр бүлийн тунхгийг бэлтгэсэн

билээ. Энэ нь өнөөдөр илүү хамаатай болоод байна. Бид “эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтийг Бурхан заяасан бөгөөд гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдаг.

“Бурхан бүх хүн төрөлхтөн, эрэгтэй эмэгтэй хүмүүсийг өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн. Хүн бүр тэнгэрлэг эцэг эхийн хайртай сүнслэг хүү, охин нь бөгөөд ийм учраас хүн бурханлиг шинж чанар, хувь тавилантай юм. Хүйс бол хувь хүний мөнх бус байдлын өмнөх, мөнх бус болон мөнхийн амьдралын тодорхойлолт ба зорилгын салшгүй шинж чанар юм. . . .

“Бурханы Адам, Ева хоёрт өгсөн анхны зарлиг нь тэд эхнэр нөхрийн хувьд эцэг эх болж чадах боломжийн талаар байлаа. Өөрийн хүүхдүүдээ, өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж газар дэлхийг дүүргэ хэмээсэн Бурханы зарлиг нь хүчин төгөлдөр байгааг бид тунхаглаж байна. Түүнчлэн үр удмаа үлдээх энэхүү нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр нөхөр болох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой хэмээн Бурхан зарлигласныг тунхаглаж байна.

“Мөнх бус амьдралыг бий болгох арга зам нь тэнгэрээс тогтоогдсон гэдгийг бид тунхагладаг. Бурханы мөнхийн төлөвлөгөөн дэх амьдралын цэвэр ариун байдал болон үүний чухал ач холбогдлын талаар бид батлан хэлж байна” хэмээн тунхаглаж байна.

Одоо хүндэт найз нараа “Ариун явдлын гэрээгээ зорчин, . . . гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй хувь хүн хожмын нэг өдөр Бурханы өмнө очиг мэдүүлэх болно. Түүнчлэн гэр бүлээ сарниулбал эрт эдүгээгийн бошиглогчдын зөгнөн хэлснээр хувь хүн, нийгэм, улс үндэстнүүдэд гай гамшиг авчрах болно гэдгийг бид сануулан” анхааруулж байна (“Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг,” Ensign, 1995 оны Арваннэгдүгээр сар, 102).

Хэрэв та энэхүү өргөх тунхагт анхаарлаа хандуулах аваас ах, эгч нараа, та бүхэн адислагдах болно. Бурхан амьд мөн бидэнд хайртай.³⁵ Түүний тусалцаагайгаар бид өөрсдийн итгэл мөн гэр бүлээ хөгжүүлж чадна. Их Эзэнээс ирсэн энэхүү амлалтыг: “Хэрэв эр хүн мийн үгээр шинэ бөгөөд үүрдийн гэрээгээр нэг эхнэртэй гэрлэж, мөн Ариун Сүнсээр тэдэн дээр лацгагдвал, . . . [тэд] хаан ширээнүүд, хаант улсууд, вант улсууд, хүчнүүд [мөн] эзэгнэлүүдийг өвлөх болно” (С ба Г 132:19) хэмээн бид баталгаажуулж чадна.

Та нарын итгэл болон гэр бүл тань та нарт агуу баяр баяслыг энд болоод үүнээс цаашид ч авчирсаар байх болно гэдгийг би гэрчилж байна. Бурхан амьд. Есүс

бол Христ. Түүний Сүм сэргээгдсэн. Бид Түүний бошиглогч Ерөнхийлөгч Гордон Б.Хинклигээр удирдагддаг. Энэ Сүмийн хайрт залуу насанд хүрэгчид та бүгдийн хүн тус бүр дээр би өөрийн хайр болон адислалыг үлдээж байна, Есүс Христийн нэрээр, амэн.

Тэмдэглэл

1. 1 Коринт 11:11-ийг үз.
2. “Израилын найдвар” *Дуулал*, 121-ийг үз.
3. 1 Коринт 15:40–41; С ба Г 76:50–113; 88:17–32 болон Иосеф Смитийн Орчуулга, 1 Коринт 15:40-ийг үз.
4. 1 Нифай 10:18; Мозая 15:19; Алма 12:25, 30; 18:39; 22:13–14; 42:26 болон С ба Г 76:12–13-ыг үз.
5. Эртний Дэлхийн хүмүүст Их Эзэн, “Миний Эцэгээр ерөөгдөгсөд өө, та нар нааш ир. Ертөнцийн сууриас та нарт бэлтгэсэн хаанчлалыг өвлөн ав” гэж заасан (Матай 25:34). Эртний Америкийн хүмүүс ч бас “Израилын Ариун Нэгэнд итгэсэн тэд . . . дэлхийн сууринаас тэдэнд бэлтгэгдсэн тэр Бурханы хаант улсыг өвлөнө . . .” гэж заагджээ (2 Нифай 9:18; Ифэр 4:19-ийг мөн үз).
6. Иохан 17:5, 24; 1 Петр 1:19–20; Мозая 4:6–7; 18:13; 3 Нифай 26:3–5; С ба Г 93:7–9; Мосе 5:57 болон ИСО, Эхлэл 5:43; 14:30–31-ийг үз.
7. Абрахам 3:24–25-ыг үз.
8. 2 Нифай 27:10-ыг үз.
9. С ба Г 124:40–41-ийг үз.
10. С ба Г 128:18-ыг үз.
11. С ба Г 138:47–48-ыг үз; түүнчлэн С ба Г 2:1–3; 110:14–16 болон Иосеф Смитийн Түүх 1:39-ийг үз.
12. Алма 13:3, 5, 7; С ба Г 132:28; 138:55–56 болон Абрахам 3:22–23-ыг үз.
13. Абрахам 3:23-ыг үз.
14. Иеремиа 1:4–5-ыг үз.
15. 2 Нифай 3:5–15 болон С ба Г 127:2; 138:53–55-ыг үз.
16. С ба Г 138:53-ыг үз.
17. Лук 11:49–51-ийг үз.
18. С ба Г 49:16–17-г үз.
19. Ефес 1:5-ыг үз. Паул мөн Бурхан “биднийг ажил үйлсээр минь биш, харин Өөрийнхөө зорилго болон бүх л өнө мөнхөөс Христ Есүс дотор бидэнд соёрхсон нигүүлслийн дагуу аварсан. Тэр биднийг ариун дуудлагаар дуудсан байна” гэж заасан (2 Тимот 1:9; түүнчлэн

- С ба Г 38:1–4 болон Абрахам 3:22–26-г үз).
Мормоны Ном нь “Их Эзэний гэрээнүүдийг тэд мэдэж болохын тулд, тэд үүрд зайлуулагдахгүй байхын тул Их Эзэн тэдний эцэг өвгөдөд ямар агуу зүйлүүдийг хийж өгснийг Израилын угсааны үлдэгдэлд үзүүлэхийн” тулд байгааг тэмдэглэх нь чухал юм (Мормоны Номны эхний хуудас).
20. С ба Г 130:20–21; 132:5, 11–12-ыг үз.
21. 2 Нифай 2:11–13-ыг үз.
22. ИСО, Илчлэлт 12:6–8-ыг үз.
23. David Popenoe болон Barbara Defoe Whitehead, *The State of Our Unions: The Social Health of Marriage in America 2004* (Rutgers University: The National Marriage Project, 2004 оны Зургадугаар сар) 16–18; (<http://marriage.rutgers.edu/>).
24. Popenoe and Whitehead, *The State of Our Unions*, 21–23-ыг үз.
25. Jason Fields, “America’s Families and Living Arrangements: 2003,” U. S. Census Bureau, 2004 оны Арваннэгдүгээр сар, 12–13 (www.census.gov/prod/2004pubs/p20-553.pdf).
26. Popenoe and Whitehead, *The State of Our Unions 20–21*-ийг үз.
27. B. J. Sigismund, “XXX-ceptable,” *Newsweek Web Exclusive*, 2003 Зургадугаар сарын 3 (www.keeper-media.com/pubs/Newsweek/2003/07/02/309790). Порнографи бол Нэгдсэн Улсад жилд 12 тэрбум доллар олдог том бизнес юм (www.internetfilterreview.com/internet-pornography-statistics.html)-ыг үз.
28. Моронай 10:32; ИСО, Матай 16:26-г үз.
29. Үйлс 3:20–21-ийг үз.
30. Даниел 2:28, 31–44 болон С ба Г 65:2–6; 124:45-ыг үз.
31. Bruce R. McConkie, *The Millennial Messiah* (1982), 672-ыг үз.
32. Ефес 3:17–19; Колоссай 2:6–7-г үз; түүнчлэн Хиламан 5:12-ыг үз. Ухаалаг хүн элсэн дээр биш харин чулуун дээр байшингаа барьдгийг сана (Матай 7:24–27-г үз).
33. С ба Г 130:20–21-ийг үз.
34. Хэн нэгний хэтийн төлөв далайцаараа мөнхийнх байх ёстой. Паул, “Хэрэв бид зөвхөн энэ амьдралдаа Христ дотор найдсан бол бид бүх хүмүүсээс хамгийн өрөвдөлтэй нь болно” гэж заасан (1 Коринт 15:19).
35. 1 Нифай 11:16–17-г үз.